



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/155/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.22 № 112

танай _____-ны № _____-т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АЮУШМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 88.3 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020125



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>530121697.64</u>	<u>482900568.08</u>
33	АВЛАГА	0.00	1214698.00
335	Бусад авлага	0.00	1214698.00
3351	Байгууллагаас авах авлага		1214698.00
35	БАРАА МАТЕРИАЛ	530121697.64	481685870.08
351	Түүхий эд материал	512608357.44	438599799.88
35110	Тусгай зориулалттай материал	173621105.12	172602233.75
35130	Эм боох материал	338987252.32	265997566.13
354	Хангамжийн материал	17063340.20	27126070.20
35410	Бичиг хэргийн материал	560000.00	2833175.00
35420	Аж ахуйн материал	16203118.20	23415818.20
35470	Бусад хангамжийн материал	300222.00	877077.00
35600	Мал амьтад	450000.00	15960000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>883634772.14</u>	<u>955424025.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	883634772.14	955424025.37
392	Биет хөрөнгө	752611772.17	823752025.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	569256054.00	567751054.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22551250.73	-44210862.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	230012123.67	305548323.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-180096201.05	-194195159.45
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	740776627.25	557276389.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-607913945.25	-400525707.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29901049.00	39337000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6772684.72	-7229011.66
393	Биет бус хөрөнгө	131022999.97	131671999.93
39301	Програм хангамж	1180000.00	2280000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-157000.03	-608000.07
39303	Бусад биет бус хөрөнгө	130000000.00	130000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,413,756,469.78</u>	<u>1438324593.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>1214698.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	1214698.00
413	Өглөг	0.00	1214698.00
4136	Бусад өглөг	0.00	1214698.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1214698.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1413756469.78</u>	<u>1437109895.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1413756469.78	1437109895.45
512	Хуримтлагдсан үр дүн	933633069.49	956986495.16
51210	Өмнөх үеийн үр дүн	933633069.49	933633069.49
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	23353425.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	480123400.29	480123400.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1413756469.78</u>	<u>1438324593.45</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,959,766,398.23	4,091,908,260.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,886,411,520.23	2,515,831,961.86
120	Нийтлэг татварын бус орлого	3,886,411,520.23	2,515,831,961.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,886,192,520.23	2,515,831,961.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,389,000.00	1,387,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,884,803,520.23	2,514,444,961.86
120009	Бусад орлого	219,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,073,354,878.00	1,576,076,299.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	564,901,700.00	613,463,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	564,901,700.00	613,463,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,508,453,178.00	962,612,999.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	231,948,176.00	295,513,609.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,274,566,990.00	666,299,390.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,938,012.00	800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,546,009,928.45	4,068,554,835.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,546,009,928.45	4,068,554,835.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,537,501,367.42	4,040,558,147.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,645,850.24	429,767,008.00
210101	Үндсэн цалин	358,645,850.24	429,767,008.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,352,623.00	57,765,763.00
210201	Тэтгэврийн даатгал	30,499,322.00	36,811,559.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,588,156.00	4,414,769.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,371,200.00	7,780,268.00
210204	Ажилгүйдлийн даатгал	717,632.00	796,289.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,176,313.00	7,962,878.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,233,915.00	15,532,844.00
210301	Гэрэл, цахилгаан	3,574,700.00	3,574,700.00
210302	Түлш, халаалт	7,679,500.00	10,585,849.00
210303	Цэвэр, бохир ус	979,715.00	1,372,295.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,214,350.28	36,217,361.60
210401	Бичиг хэрэг	6,202,821.00	6,560,800.00
210402	Тээвэр, шатахуун	22,355,632.00	15,700,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,262.97	4,554,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,760,382.00	2,479,630.00
210408	Бараа материал акталсны зардал	40,695,252.31	6,922,011.60
2105	Нормативт зардал	2,369,132,400.20	2,498,354,897.89
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,369,025,420.20	2,498,354,897.89



210502	Хоол, хүнс	106,980.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,641,800.00	5,158,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,570,200.00
210604	Урсгал засвар	1,641,800.00	3,588,030.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,504,531,422.76	920,960,975.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,503,618,422.76	919,084,775.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,000.00	294,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	221,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,749,005.94	76,801,067.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,470,606.00	8,205,120.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,278,399.94	68,595,946.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,508,561.03	27,996,688.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	792,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	792,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,008,561.03	27,204,688.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,008,561.03	27,179,548.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		25,140.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,413,756,469.78</u>	<u>23,353,425.67</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,413,756,469.78</u>	<u>23,353,425.67</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,074,995,878.00</u>	<u>1,577,463,299.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,641,000.00	1,387,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,641,000.00	1,387,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,422,000.00	1,387,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,422,000.00	1,387,000.00
120009	Бусад орлого	219,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,073,354,878.00	1,576,076,299.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	564,901,700.00	613,463,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	564,901,700.00	613,463,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,508,453,178.00	962,612,999.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	231,948,176.00	295,513,609.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,274,566,990.00	666,299,390.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,938,012.00	800,000.00



2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,011,654,277.00	1,576,363,299.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,011,654,277.00	1,576,363,299.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,003,145,715.97	1,548,366,611.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,624,100.00	88,849,900.00
210101	Үндсэн цалин	54,877,000.00	65,164,500.00
210102	Нэмэгдэл	10,083,700.00	20,022,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,663,400.00	3,663,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,578,200.00	11,994,700.00
210201	Тэтгэврийн даатгал	5,833,100.00	8,440,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	686,300.00	888,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	549,100.00	710,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	137,200.00	177,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,372,500.00	1,777,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,233,915.00	15,532,844.00
210301	Гэрэл, цахилгаан	3,574,700.00	3,574,700.00
210302	Түлш, халаалт	7,679,500.00	10,585,849.00
210303	Цэвэр, бохир ус	979,715.00	1,372,295.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,298,112.97	26,789,320.00
210401	Бичиг хэрэг	5,106,100.00	6,534,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,591,870.00	15,700,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,600,142.97	4,554,320.00
2105	Нормативт зардал	8,836,100.00	13,900,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,100,500.00	10,664,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,600.00	3,235,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,153,500.00	12,802,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,285,200.00	2,677,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,350,000.00
210604	Урсгал засвар	10,868,300.00	5,775,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,866,543,088.00	1,377,618,567.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,865,630,088.00	1,375,742,367.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,000.00	294,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	221,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	878,700.00	878,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	878,700.00	878,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,508,561.03	27,996,688.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	792,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	792,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,008,561.03	27,204,688.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,008,561.03	27,179,548.00
213304	Хөрөнгийн		
213305	Нэмэлт сахүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		25,140.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63,341,601.00	1,100,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,341,601.00	1,100,000.00



22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,341,601.00	1,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,341,601.00	1,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,341,601.00	1,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(63,341,601.00)</u>	<u>(1,100,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-480,123,400.29	0.00	-480,123,400.29
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-480,123,400.29	0.00	-480,123,400.29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	480,123,400.29	0.00	0.00	480,123,400.29
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,413,756,469.78	0.00	1,413,756,469.78
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	480,123,400.29	933,633,069.49	0.00	1,413,756,469.78
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	480,123,400.29	933,633,069.49	0.00	1,413,756,469.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	480,123,400.29	933,633,069.49	0.00	1,413,756,469.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,353,425.67	0.00	23,353,425.67
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	480,123,400.29	956,986,495.16	0.00	1,437,109,895.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	614,963,300.00	587,670,752.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	614,963,300.00	587,670,752.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	614,171,300.00	586,878,752.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,849,900.00	88,849,900.00
210101	Үндсэн цалин	65,164,500.00	65,164,500.00
210102	Нэмэгдэл	20,022,000.00	20,022,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,663,400.00	3,663,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,994,700.00	11,994,700.00
210201	Тэтгэврийн даатгал	8,440,700.00	8,440,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	888,500.00	888,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	710,800.00	710,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	177,700.00	177,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,777,000.00	1,777,000.00



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,541,900.00	15,532,844.00
210301	Гэрэл, цахилгаан	3,574,700.00	3,574,700.00
210302	Түлш, халаалт	10,586,400.00	10,585,849.00
210303	Цэвэр, бохир ус	1,380,800.00	1,372,295.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,963,400.00	26,789,320.00
210401	Бичиг хэрэг	6,701,700.00	6,534,400.00
210402	Тээвэр, шатахуун	15,700,600.00	15,700,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,561,100.00	4,554,320.00
2105	Нормативт зардал	14,050,100.00	13,900,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,814,500.00	10,664,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,235,600.00	3,235,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,802,400.00	12,802,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,677,100.00	2,677,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,350,000.00	4,350,000.00
210604	Урсгал засвар	5,775,300.00	5,775,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	443,090,200.00	416,130,708.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	439,530,600.00	413,154,508.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,000.00	294,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	304,600.00	221,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	480,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	878,700.00	878,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	878,700.00	878,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	792,000.00	792,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	792,000.00	792,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	792,000.00	792,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	614,963,300.00	614,850,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	613,463,300.00	613,463,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	613,463,300.00	613,463,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	1,387,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	1,387,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	41.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан		



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,504,435,288.00	962,612,999.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,504,435,288.00	962,612,999.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,504,435,288.00	962,587,859.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,504,435,288.00	962,587,859.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,504,435,288.00	962,587,859.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	25,140.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		25,140.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,504,435,288.00	962,612,999.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,504,435,288.00	962,612,999.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,504,435,288.00	295,513,609.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		666,299,390.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		800,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Аюушмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймагт дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ариутгал, халдваргүйтгэл
- Урьдчилан сэргийлэх дархлаажуулалт
- Сургалт, сурталчилгаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 онд Мал эмнэлгийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 58,160.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, уг зөрчилд 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн байна. Өгсөн 58,160.5 мянган төгрөгийн албан шаардлага, 4 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 4,100,513.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 82,010.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн тайлангийн мөн зардлын 4,068,554.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 81,371.1 мянган төгрөгөөр өөрчлөн тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,353.4 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	1,214.7	1,214.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	530,121.7	481,685.9	-48,435.8
Үндсэн хөрөнгө	883,634.8	955,424.0	71,789.2
Нийт хөрөнгө	1,413,756.5	1,438,324.6	24,568.1
Өр төлбөр	0.0	1,214.7	1,214.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,413,756.5	1,437,109.9	23,353.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,413,756.5	1,438,324.6	24,568.1

Авлага дансны үлдэгдэл 1,214.7 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар суутган авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 481,685.9 мянган төгрөг болж 48,435.8 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Биет бус хөрөнгө өссөн нь өөрийн төсвийн хөрөнгөөр санхүүгийн програм худалдан авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 1,214.7 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар суутган авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,437,109.9 мянган төгрөг болж 23,353.4 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө акталснаас болж элэгдлийн зардал буурсантай холбоотой байна.

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,867,858.1 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 2,495,665.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө, бараа материал байна.

Нийт зардал өмнөх оноос 477,455.1 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, бараа материал, бусдаар



гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 998,153.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 998,153.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 60,068.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 383,190.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 614,963.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 613,463.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 613,463.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1,387.0 мянган төгрөг, нийт 614,850.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 587,670.8 мянган төгрөгийг зарцуулж, 27,179.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 587,670.8 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь зардлыг 27,179.5 мянган төгрөгөөр дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээ 27,179.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 295,513.6 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 666,299.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 800.0 мянга, нийт 962,613.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 962,587.9 мянган төгрөгийг зарцуулж, 25.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 125 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 21 мэдээлэл байна.



3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 24,900.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0			
Албан шаардлага	1	24,900.0	1	24,900.0			0
Зөвлөмж	1	500.0	1	500.0			0
Нийт дүн	2	25,400.0	2	25,400.0			0

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,327.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,327.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд 1,214.7 мянган төгрөгийн алдааг авлага, өглөгөөр тусгуулж залруулга хийлгэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,327.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,327.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар 1,214.7 мянган төгрөгийг суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:", 22.1.2-д "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 1,500.0 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн ч төсвийн орлого 113.0 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс нийт 21 мэдээллийн хугацааг хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн



дотор мэдээлнэ.” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/155/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар 1,214.7 мянган төгрөгийг суутгасан.	1,214.7	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Ч.Аюушмаа, Э.Цэвээнжав
2	Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 1,500.0 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн ч төсвийн орлогыг 113.0 мянган төгрөгөөр тасарсан.	113.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Ч.Аюушмаа, Э.Цэвээнжав
3	Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс нийт 21 мэдээллийн хугацааг хоцроосон.	0.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Ч.Аюушмаа, Э.Цэвээнжав
ДҮН		1,327.7			

